

Японы Хүүхдийг Ивээх Сан
СУРГАЛТЫН ЦАХИМ МОДУЛЬ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ

Төслийн товч танилцуулга

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр нь 2024 оны 4 дүгээр сараас эхлэн Японы Гадаад Харилцааны Яамны санхүүжилтээр “ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ, ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ” төслийг Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн 10 хүүхдийн цэцэрлэг, 10 өрхийн эрүүл мэндийн төв, 5 салбар комиссыг хамруулан хэрэгжүүлж байна.

Үндэслэл, хэрэгцээ шаардлага

Дээрх төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст зориулсан сургалтын гарын авлага”, цэцэрлэгийн багш, эцэг эхчүүдэд зориулсан “Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”, “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг, оролцоог нэмэгдүүлэх арга зүй”, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан “Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх” сэдэвт сургалтын 4 модулийг тус тус боловсруулж, холбогдох сургалтуудыг зохион байгуулсан юм. Одоо эдгээр сургалтын модулиудыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, төсөлд хамрагдаагүй орон нутгийн өрхийн эмнэлэг, цэцэрлэгийн багш эмч нар, салбар комиссын гишүүдэд зайнаас онлайн хэлбэрээр суралцах боломж бүрдүүлэх зорилгоор цахим модулийн хэлбэрт нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Зорилго

Төслийн хүрээнд боловсруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст зориулсан сургалтын гарын авлага”, “Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”, “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг, оролцоог нэмэгдүүлэх арга зүй”, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан “Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх” сэдэвт 4 модулийг зайнаас суралцах боломжтой сургалтын цахим хэлбэрт нийцүүлэн боловсруулах

Ажлын гүйцэтгэх даалгавар

Дээрх сургалтын модулиудын агуулгыг **доорх бүтэц, жишгийн** дагуу модуль тус бүрийн зөвлөх багтай хамтран сургалтын цахим хэлбэрт нийцүүлэн шинэчлэн боловсруулна.

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст зориулсан сургалтын гарын авлага”, 123 хуудас бүхий сургалтын модуль

	Цахим түлхүүр агуулга , мэдээлэл	PPT Танилцуулга	Цахим дасгал, бие даан суралцах даалгавар	Мэдлэг, чадварын үнэлгээний цахим сорил
1 дүгээр бүлэг	2 хуудас	1	1 хуудас	1 хуудас
2 дугаар бүлэг	10 хуудас	2	2 хуудас	1 хуудас
3 дугаар бүлэг	10 хуудас	2	5 хуудас	3 хуудас
4 дугаар бүлэг	1 хуудас	2	5 хуудас	2 хуудас

2. “Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх” 176 хуудас бүхий сургалтын модуль

	Цахим түлхүүр агуулга , мэдээлэл	PPT Танилцуулга	Цахим дасгал, бие даан суралцах жишээ	Мэдлэг, чадварын үнэлгээний цахим сорил
1 дүгээр бүлэг	10 хуудас	2	2 хуудас	1 хуудас
2 дугаар бүлэг	25 хуудас	2	3 хуудас	2 хуудас
3 дугаар бүлэг	10 хуудас	2	2 хуудас	2 хуудас
4 дүгээр бүлэг	10 хуудас	2	2 хуудас	1 хуудас

3. “Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль” 178 хуудас бүхий сургалтын модуль

	Цахим түлхүүр агуулга , мэдээлэл	PPT Танилцуулга/ видео	Цахим дасгал, бие даан суралцах жишээ	Мэдлэг, чадварын үнэлгээний цахим сорил
1 дүгээр бүлэг	15 хуудас	2	2 хуудас	1 хуудас
2 дугаар бүлэг	25 хуудас	2	3 хуудас	2хуудас

Здугаар бүлэг		2	2 хуудас	
	20 хуудас			2 хуудас

4. “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, үүрэг, оролцоог нэмэгдүүлэх арга зүй”, 67 хуудас бүхий сургалтын модуль

	Цахим түлхүүр агуулга , мэдээлэл	PPT Танилцуулга/ видео	Цахим дасгал, бие даан суралцах жишээ	Мэдлэг, чадварын үнэлгээний цахим сорил
1 дүгээр бүлэг	20 хуудас	2	2 хуудас	1 хуудас
2 дугаар бүлэг	20 хуудас	2	2 хуудас	1 хуудас
		Видео багц		

Ажлын хүрээ, хугацаа

Үйл ажиллагаа	Хугацаа
Модуль тус бүрийн зөвлөх багтай хамтран цахим агуулгын 3 төсөл боловсруулах	2026.10.01- 2026.11.01
Цахим модулийн эхний төсөл хүлээлгэн өгөх	2026.11.02
Төслийн баг, зөвлөхүүдийн саналын дагуу төслийг засварлан сайжруулах	2026.11.02-2026.11.15
Цахим модулийг турших, засварлах	2026.11.16-2026.11.30
Цахим модулийг хүлээлгэн өгөх	2026.12.05

Ажил гүйцэтгэх байгууллагад тавигдах ерөнхий шаардлага:

- Цахим сургалтын материал боловсруулж байсан туршлагатай
- Цахим сургалтын агуулга бүтээх, турших, тохируулах техникийн хүчин чадалтай, өөрийн эзэмшдэг сайт, мэдээллийн хуудастай байх
- *Интерактив веб ажиллах орчин, Linux үйлдлийн систем дээр MySQL, PHP технологи програмчлалын хэл ашигладаг байх*
- Цахим программ хангамж, материал боловсруулах чиглэлээр мэргэшсэн хүний нөөцтэй (3 аас доошгүй мэргэжилтэнтэй)
- Зөвлөх баг, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах чадвартай

Санал авах хугацаа: Дээрх ажлыг гүйцэтгэх туршлага, чадвар бүхий байгууллага саналаа 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 17.00 цагаас өмнө Хүүхдийг Ивээх Санд бичгээр эсхүл электрон хэлбэрээр (pdf өргөтгөлөөр) mongolia.procurement@savethechildren.org хаягаар ирүүлнэ.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Шалгаруулалтад оролцох хүсэлт захидал

- Байгууллагын танилцуулга (байгууллагын танилцуулга, мэргэжилтнүүдийн мэдээлэл, анкет)
- Ижил төстэй ажлыг зохион байгуулж байсан туршлага (мэдээлэл, жишээ болохуйц контентууд)